| 210807 | Газрын төлбөр | | | 18000.00 | 7440.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 0.00 | 81825300.00 | 70856223.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 75243000.00 | 64673135.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | | 6582300.00 | 6183088.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 0.00 | 62426500.00 | 61153232.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 0.00 | 62426500.00 | 61153232.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | | 5953400.00 | 5953000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | | 19053700.00 | 18726242.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | | 32119400.00 | 31569190.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | 5300000.00 | 4904800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 | 217922000.0 | 122949950.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.0 | 0.0 | 217922000.0 | 122949950.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | | | 0 | 0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.00 | 0.00 | 134032200.0 | 36000000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | | | 134032200.0 | 36000000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 0.00 | 286981950.00 | 2749092897.40 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 1661064200.00 | 1646430147.51 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | | 1559363700.00 | 1544729647.51 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | | 101700500.00 | 101700500.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 1022151900.00 | 941289269.89 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | | | 1022151900.00 | 941289269.89 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 32376900.00 | 29704880.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | | 32376900.00 | 29704880.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 0.00 | 0.00 | 154226500.00 | 131668600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | 118158400.00 | 117618600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | 13000000.00 | 14050000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | | 23068100.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | 18068173.10 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | 162511354.16 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 0.00 | 0.00 | 6.00 | 6.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | | | 6.00 | 6.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.00 | 0.00 | 142.00 | 142.00 |
| 620001 | Удирдах ажилтан | | | 11.00 | 11.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | | 86.00 | 92.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | 37.00 | 32.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | 8.00 | 7.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 0.00 | 0.00 | 863.00 | 746.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 0.00 | 0.00 | 693.00 | 576.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | | | 693.00 | 576.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 0.00 | 0.00 | 170.00 | 170.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | | | 170.00 | 170.00 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | 0.00 | 0.00 | 358.00 | 448.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсэдийн тоо | | | 358.00 | 448.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0.0 | 0.0 | 142.0 | 142.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | | 10.00 | 11.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | | 49.00 | 51.00 |

Дарьганга сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|--------|---|--|--|-------|-------|
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ) | | | 5.00 | 5.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | | 20.00 | 20.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | | 43.00 | 41.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | | 8.00 | 3.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | | 7.00 | 11.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|---|-------------|---------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 286414247.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 286414247.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 252914247.21 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 30214763.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 328500.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 29886263.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 3709799.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 3613139.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 24164.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 48329.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 4832.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 19331.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 0.00 | 11288600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 125000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 11163600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.00 | 11437180.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 825800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 7786080.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 195000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 1736800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 893500.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 56843962.96 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 55190562.96 |
| 210502 | Хоол, хүнс | | 1513400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 140000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.00 | 6509000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 920000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 5589000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 1695200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1379200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 316000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 99187282.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 88521226.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 10666056.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 33500000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 33500000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 33500000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 32028460.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 32028460.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 287418472.50 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 287418472.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 4869000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 117439641.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 45354531.50 |

Дарьганга сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | |
|--------|--|--------------|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 119755300.00 |
| | Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1004225.29 |

3. Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Д.Болдбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогын данстай холбоотой боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Ариунзул гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 02/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, бодлого шийдвэр зохицуулалт, үйлчилгээгээр ханган төрийн захиргааны удирдлагын манлайлал, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх хуулиа дээдэлсэн, ил тод байдалд суурилсан хөгжлөөрөө манлайлсан улс аймгийн тэргүүний сум болох ” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2021 онд үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 2,489.1 сая төгрөгийн зардлын 1 хувь буюу 24.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 103.6 сая, эцсийн үлдэгдэл 350.7 сая төгрөг болж, 247.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|----------------------------|----------------|-----------------|------------------------|-----------------|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0.2 | 0.06 | -0.13 | |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 10.8 | 10.2 | -0.6 | 2.9 |
| Төрийн сангийн харилцах | 92.5 | 340.5 | 248.0 | 97.1 |
| Хадгаламж | - | - | - | - |
| Дүн | 103.6 | 350.7 | 247.1 | 100 |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 350.7 сая төгрөгийн 340.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.06 сая төгрөг касст байгаа бэлэн мөнгө, 10.2 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийн 96.2 сая төгрөг буюу 28.2 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, 59.7 сая төгрөг буюу 17.5 хувийг ОНХС-ийн төсөл арга хэмжээний санхүүжилт, 7.5 сая төгрөг буюу 2.2 хувийг эрүүл мэндийн төвийн харилцах дансны үлдэгдэл, төлөвлөснөөс давсан татварын болон татварын бус орлого 176.9 сая төгрөг буюу 51.9 хувийг тус тус эзэлж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 254.7 сая, эцсийн үлдэгдэл 252.4 сая төгрөг болж, 2.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1.2 | 0.9 | -0.3 |
| Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | | 0.3 | 0.3 |
| Байгууллагаас авах авлага | 29.1 | 102.2 | 73.1 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 224,3 | 148.9 | -75.4 |
| Дүн | 254.7 | 252.4 | -2.3 |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага байгаа бөгөөд Дарьганга тохижилт ОНӨААТҮГ-ын өмнөх жилүүдэд үүссэн авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүйгээс олон жилийн насжилттай авлага үүссэн байна.

Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 143.9 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 54.3 сая, бусад байгууллага, хувь хүнээс авах авлага 54.2 сая төгрөг байна. Авлагын дансны үлдэгдлийн 57 хувь нь Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, 1.8 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлсөнд төлбөрийн акт тогтоов. /ЕБС/
- Байгууллагаас авах, хувь хүнээс авах нийт 0.06 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй./ЕБС/

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 250.2 сая, эцсийн үлдэгдэл 205.1 сая төгрөг болж, 45.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Тусгай зориулалттай материал | 6.5 | 11.1 | 4.6 |
| Эм боох материал | 54.8 | 44.5 | -10.3 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 1.5 | 0.12 | -1.37 |
| Бичиг хэргийн материал | 7.8 | 7.2 | -0.6 |
| Аж ахуйн материал | 119.1 | 85.9 | -33.2 |
| Сэлбэг хэрэгсэл | 2.1 | 1.9 | -0.2 |
| Түлш тослох материал | 0.4 | 0.8 | 0.4 |
| Барилга засварын материал | 5.0 | 6.7 | 1.7 |
| Хүнсний материал | 5.3 | 4.7 | -0.6 |
| Бусад хангамжийн материал | 22.8 | 25.9 | 3.1 |
| Мал амьтад | 24.8 | 16.1 | 8.7 |
| Дүн | 250.2 | 205.1 | -45.1 |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 205.1 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуй, эм боох, түлш тослох, бусад хангамжийн материал болон мал амьтдын үлдэгдэл нь гол нөлөөлж байна.

Бараа материалын дансны 205.1 сая төгрөгийн үлдэгдлийн 58 хувийг аж ахуйн материал эзэлж байгаа бөгөөд сэлбэг хэрэгсэл бусад хангамжийн материал, эм боох материал, мал амьтдын үлдэгдэл гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн 32.6 хувийг Засаг даргын Тамгын газар, 11.8 хувийг Хүүхдийн цэцэрлэг, 11.6 хувийг Эрүүл мэндийн төв, 24.1 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 5.5 хувийг Соёлын төв зэрэг байгууллагууд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, 1.8 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлсөнд төлбөрийн акт тогтоов. /ЕБС/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,874.4 сая, эцсийн үлдэгдэл 3,374.4 сая төгрөг болж, 1,500.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------|----------------|-----------------|------------------------|
| Барилга байгууламж | 3,016.2 | 2,971.7 | -44.5 |
| Тээврийн хэрэгсэл | 361.9 | 364.1 | 2.2 |
| Машин тоног төхөөрөмж | 592.2 | 516.4 | -75.8 |
| Тавилга эд хогшил | 328.9 | 287.4 | -41.5 |
| Зам гүүрний байгууламж | 43.3 | 43.3 | 0.0 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 54.7 | 54.7 | 0.0 |
| Номын фонд | 50.2 | 54.3 | 4.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 339.1 | 399.8 | 60.7 |
| Программ хангамж | 3.0 | 2.3 | -0.7 |
| Бусад биет бус хөрөнгө | 84.6 | 84.6 | 0 |
| Дүн | 4,874.4 | 4,778.7 | -95.7 |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 26.6 сая, балансас балансад шилжүүлэн авсан 26.9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 162.9 сая, бусад 3.3 сая, нийт 219.8 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан хөрөнгө 295.6 сая шилжүүлсэн 19.8 сая, нийт 315.5 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв. /ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,048.3 сая, эцсийн үлдэгдэл 964.7 сая төгрөг болж, 83.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|-----------------------------|----------------|-----------------|------------------|-----------------|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 36.4 | 47.9 | 11,5 | 4,9 |
| Байгууллага төлөх өглөг | 114.3 | 94.5 | -19,8 | 9,8 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 25.8 | 26.5 | 0,7 | 2,7 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 18.8 | 22.3 | 3,5 | 2,3 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 7.1 | 10.4 | 3,3 | 1,07 |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | 9.4 | | -9,4 | 0 |
| Бусад урьдчилж орсон орлого | 836.3 | 763.0 | - | |
| | | | 73.3 | 80 |
| Нийт дүн | 1,048.3 | 964.7 | -83.6 | 100 |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 47.9 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 94.5 сая төгрөгийн байгууллагад төлөх, 26.4 сая төгрөг хувь хүнд төлөх өглөг, 22.3 сая төгрөгийн татварын өглөг, 710.4 сая төгрөгийн НДШ-ийн өглөг

/ТӨҮГ/, 763.0 сая төгрөгийн бусад урьдчилж орсон орлого, нийт 964.7 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Өр төлбөр өндөр байгаа нь Дарьганга тохижилт ОНӨААТҮГ өмнөх онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг залруулж хойшлогдсон орлогоор бүртгэж, жил бүр капиталжуулж байгаа нь өр төлбөрт нөлөөлсөн байна.
Аудитын илрүүлэлт:

Илрүүлэлт:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдөж өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсны дараа төлж барагдуулах зөвлөмж өгөв. /Дарьганга Тохижилт/

- Байгууллага, хувь хүнд өгөх нийт 0.1 сая төгрөгийн өр үүссэнд зөвлөмж хүргүүлэв. /ЕБС/

3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,495.8 сая, эцсийн үлдэгдэл 2,786.7 сая төгрөг болж, 290.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,141.9 сая, эцсийн үлдэгдэл 3,280.4 сая төгрөг болж, 138.5 сая төгрөгөөр өссөн байна.

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт+/, бууралт -/ | Дүнд эзлэх хувь |
|---|----------------|-----------------|---------------------|-----------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,764.5 | 3,764.5 | 0 | |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 0.2 | -0.2 | |
| Хуримтлагдсан үр дүн | -1,023.5 | -822.5 | -201.0 | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 401.0 | 336.3 | -64.7 | |
| Дүн | 3,141.9 | 3,280.4 | 138.5 | |

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өссөн нь Дарьганга тохижилт ОНӨААТҮГ 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгийн аргаар бараа материалд бүртгэсэн байсныг залруулж бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

3.5.7 Орлогын данс

Татварын орлого 300.4 сая, зээлийн хүүгийн орлого 3.8 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 254.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 14.0 сая, борлуулалтын орлого 592.5, татварын бус орлого 29.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,559.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 101.7 сая нэмэлт санхүүжилтийн орлого 287.4 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 1,553.6 сая, ЭМД сангаас 29.7 сая, нийт 4,335.0 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

3.5.8 Зардлын данс

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,595.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 207.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 239.8 сая, хангамж, бараа материалын зардал 70.2 сая, нормативд зардал 80.8 сая, эд хогшил, урсгал

засварын зардал 34.2 сая , томилолт, зочны зардал 4.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 80.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 70.8 сая, бусад урсгал шилжүүлэг 61.1 сая , улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 113.4 сая үйл ажиллагааны бус зардалд сая нийт 2,604.6 сая төгрөг зардал тайлагнасан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 0.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Хөдөлмөрийн чадвараа алдсаны акттай 3 ажилтны цалингаас ХХОАТ-ын чөлөөлөлгүй тооцоноос 2,572.0 мянган төгрөгийг илүү суутгасан зөрчилд төлбөрийн акт тогтоов . /ЕБС 2.5 сая /
- ЭМС-ын А/498 тоот тушаалын дагуу олгогдох тэтгэмжээс үндсэн ажилтнаар томилогдоогүй 2 ажилтанд 1,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосонд албан шаардлага хүргүүлэв. /ЭМТ 1.0 сая/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дугаар сарын 30-ний өдрийн 1 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 108.1 сая төгрөг, татварын бус орлого 30.0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 160.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|--------------|--------------|-------------|--------------|
| Үйл ажиллагааны орлого | 15.0 | 14.5 | -0.5 | 96.6 |
| Суутгагчийн хувь хүнд олгосон албан татвар | 20.0 | 14.1 | -5.9 | 70.5 |
| Бууны албан татвар | 1.0 | 1.1 | 0.1 | 110 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 3.0 | 2.0 | -1.0 | 107 |
| Ус рашаан ашигласны төлбөр | 1.5 | 0.5 | -1.0 | 66.6 |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр | | 110.2 | 110.2 | 100 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 46.0 | 45.6 | -0.4 | 99.1 |
| Ургамал ашигласны төлбөр | 10.0 | 9.9 | -0.1 | 99 |
| Хог хаягдлын хураамж | 21.0 | 18.0 | -3.0 | 85.7 |
| Хүү торгуулийн орлого | 30.0 | 29.9 | -0.1 | 99.6 |
| Газрын төлбөр | 6.0 | 1.9 | -4.1 | 31.6 |
| Хөрөнгө борлуулсаны орлого | 1.5 | 4.2 | 2.7 | 280 |
| Малын тоо толгойн албан татвар | 110.3 | 78.1 | -32.2 | 70.8 |
| ТТАМАТ | 1.0 | | -1.0 | |
| Нийт дүн | 266.3 | 329.6 | 63.3 | 123.7 |

Орон нутгийн татварын орлого 63.3 сая төгрөгөөр давсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,670.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,317.1 сая төгрөгийг урсгал зардалд, 217.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 135.3 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 14.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 117.6 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 29.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,553.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,559.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 101.7 сая төгрөгийг ОНХСанд олгох орлогын шилжүүлэг нийт 1,822.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Энэ нь ЭМТөв 54.0 сая төгрөгийг санхүүжилт дутуу, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 17.9 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,604.6 сая төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үүнд: Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас 4.7 сая, ЗГНХ, ЗДНХхөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 117.4 сая, дээд шатны төсвийн захирагчаас 45.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 119.7 сая, нийт 287.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 33.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11.2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 11.4 сая, нормативд зардалд 56.8 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 6.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 99.2 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 33.5 сая төгрөг нийт 254.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 32.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 1.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 5 мэдээлэл хуульд заасан хугацаанаас хоцроож, 5 мэдээлэл мэдээлээгүй, мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 26 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, 38 мэдээллийг мэдээлээгүй тул зөвлөмж хүргүүлэв. /Цэцэрлэг, ЗДТГ, ЭМТ, ЕБС/

33.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Дарьганга сумын Засаг даргад 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь Хувь |
|----------|---------------------|-----|---------|-----|--------------|-----|---------------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зөвлөмж | 2 | - | 2 | - | - | - | 100 |
| Нийт | 2 | - | 2 | - | - | - | 100 |

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Дарьганга сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 орон нутгийн тусгайн сан, 2 ОНӨААТҮГ, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өгч, 3 байгууллага, 2 орон нутгийн тусгай сан нийт 5 газрыг түүвэрт хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,165.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11.3 сая төгрөгийг зөрчлийг залруулж, 8.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 179.7 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 965.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

4.1.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.1.2 Эрсдэл: НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот СБА-2022/06/НА-СТА-ТТЗ

тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|-------------------------------------|-----------------------------|---|---|
| Огноо: 2022.03.25 | Аудитын нэр: | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн явц | Аудитын код: СБА-2022/06/НА-СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дарьганга сумын Засаг дарга | | Сая төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|--|---|-------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зарлагыг илүү илэрхийлсэн | 102031.4 | Залруулсан | Санхүү албаны дарга | Б.Нансалмаа |
| 2 | Малын тоо толгойн албан татварын орлогыг дутуу төвлөрүүлсэн байна | 32214.3 | Төлбөрийн акт | Санхүү албаны дарга | Б.Нансалмаа |
| | Дүн | 134245.7 | | | |